



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 2/32

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тулгар төр байгуулагдсаны 2234 жилийн ой, Их Монгол улс байгуулагдсаны 819 жилийн ой, Ардын хувьсгалын 104 жилийн ой, Хэнтий аймаг үүсгэн байгуулагдсаны 102 жилийн ойн баяр наадмын өсвөрийн бөхийн барилдаанд ажмилттай сайн оролцож түрүүлсэн Хэнтий аймгийн Мөрөн сумын харьяат Гантулга овогтой Баянзулд хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 300 000 (гурван зуун мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Ц.Болорцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Н.НАМЖИЛНОРОВ

Засаг даргын Тамгын газрын даргын
2025 оны ... сарын ... өдрийн ... дугаар
тушаалын хавсралт

№	Овог	Нэр	Данс /асран хамгаалагчийн данс/	Асран хамгаалагчийн регистрийн дугаар
1	Гантулга	Баянзул	Хаан банк 5949004397	Со71082505